



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 20 өдөр

Дугаар А/366

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн "Зорилтот жилийн төлөвлөгөө батлах тухай" А/31 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын авто машины засварын зардалд 2,018,000 (хоёр сая арван найман мянга) төгрөг, "Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих жил"-ийн хүрээнд Хархорин суманд 500 га талбайд тариалж байгаа малын тэжээлийн ургамалд шаардлагатай бордоо цацах зардалд 14,974,140 (арван дөрвөн сая есөн зуун далан дөрвөн мянга нэг зуун дөч) төгрөгийг тус тус зарцуулсугай

2.Дээрх зардал болох 16,992,140 (арван зургаан сая есөн зуун ерэн хоёр нэг зуун дөч) төгрөгөөс 2,018,000 (хоёр сая арван найман мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс, үлдэгдэл 14,974,140 (арван дөрвөн сая есөн зуун далан дөрвөн мянга нэг зуун дөч) төгрөгийг өвс тэжээлийн аюулгүй нөөц бэлтгэх хөрөнгийн эргэн төлөлтөөс тус тус санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100785